



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/334


Булган сум

Сайн үйлсийн ажлыг аймгийн Скаутын холбоотой хамтран зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймагтай найрсаг хамтын ажиллагаат Бүгд Найрамдах Солонгос Улсын Скаутын Кёнги аймгийн хойд бүсийн холбоо нь Булган аймагт 2024 оны 05 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжин мод тарих, Солонгос Улсын соёл урлагийн тоглолтыг хийх, нэн шаардлагатай эмнэлгийн өрөөний тохижилтыг хийх зэрэг сайн үйлсийн ажлыг аймгийн Скаутын холбоотой хамтран зохион байгуулсугай.


2.Арга хэмжээнд шаардагдах 11,485,000 (арван нэгэн сая дөрвөн зуун наян таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

05 дугаар сарын 14-ны өдрийн /33/ дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

| д/д | Зардлын нэр | Хэмжих нэгж | Нэгж үнэ /төг/ | Нийт үнэ /төг/ |
|-----|------------------|------------------|----------------|-------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Байрны зардал | 14 өрөө /1 хоног | 8,000,000 | 8,000,000 |
| 2 | Хэвлэлийн зардал | ш /21/ | 400,000 | 400,000 |
| 3 | Бусад | - | 2,500,000 | 2,500,000 |
| 4 | Шатахуун | 132 л | Дизель-4460 | 585,000 |
| | Нийт дүн | | | 11,485,000 |